

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Захиалагч:

Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг

“Шүүх эрх мэдлийн байгууллагуудын эрх зүйн орчныг боловсронгуй болгох,
чадавхыг сайжруулах төсөл”

Гүйцэтгэгч:

Р.Очирбал

**Улаанбаатар хот
2021 он**

АГУУЛГА

Нэг. Ерөнхий мэдээлэл

Хоёр. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл батлагдан гарснаар хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцооны тайлан:

- 2.1. Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 2.2. Нэг бүрийн зардлыг тооцох;
- 2.3. Тоон үзүүлэлтийг тооцох;
- 2.4. Нийт зардлын дүнг тооцож гаргах;
- 2.5. Хялбарчлах боломжийг шалгах;
- 2.6. Нэмэлт зардлыг тооцох.

Гурав. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл батлагдан гарснаар төрийн байгууллагад үүсэх зардлын тооцооны тайлан:

- 3.1. Шинээр нэмэгдэж байгаа болон өргөжиж байгаа чиг үүргийг тогтоох;
- 3.2. Уг чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг тодорхойлох;
- 3.3. Гарах зардлыг тооцох;
- 3.4. Зардлыг нэгтгэн тооцох;
- 3.5. Хувилбарыг нягталж зардлыг бууруулах боломжийг эрэлхийлэх.

Дөрөв. Дүгнэлт, санал

ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

/Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл/

Нэг.Ерөнхий мэдээлэл

Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Төрийн болон орон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл² /цаашид **"хуулийн төсөл"** гэх/ батлагдснаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид **"аргачлал"** гэх/-ыг баримтлан доорх зардлын тооцоог хийв.

Хуулийн төсөл батлагдснаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах, бууруулах талаар санал боловсруулахад энэхүү тайлан чиглэгдэх болно.

Хуулийн төслийн зохицуулалтаар буюу хуулийн төсөл батлагдснаар зардал тээгч хуулийн этгээд, төрийн байгууллагад тодорхой зардал үүсгэхээр байна. Харин иргэнд зардал үүсэхээргүй байна.

Хуулийн төслөөс хуулийн этгээдийн хүлээж буй үүрэг, төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлохдоо уг хуулийн төсөл нь анхдагч хууль хэлбэрээр бичигдэж байгаа хэдий ч уг хуулийн төслөөр зохицуулах харилцааг одоогоор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хуулиар зохицуулж байх тул шинээр гүйцэтгэх үүргийн хүрээнд хязгаарласан болно.

Хуулийн төслөөр зөвхөн шинээр бий болж буй үүрэгт зардал тооцогдож байгаа тул бодит статистик болон хугацааг шууд ашиглах боломжгүй тохиолдол нилээд байсан тул аргачлалын 2.5.2, 4.4.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн адил төстэй ажил, үйлчилгээ байгаа эсэхийг судалж, баримжаалах зэргээр хугацаа, тохиолдлын тоо зэргийг тогтоосон болно.

¹Хууль тогтоомжийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн.

²Тус зардлын тооцооны тайланг гүйцэтгэхдээ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн А/174 дугаартай тушаалаар байгуулсан Ажлын хэсгээс боловсруулсан Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийн эхний хувилбарт үндэслэсэн болно.

Хоёр.Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл батлагдснаар хуулийн этгээдэд үүсэх зардал

Энэ хэсэгт Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл батлагдснаар хуулийн этгээдийн эрхлэх үйл ажиллагаатай холбоотой гүйцэтгэх үүргийн улмаас үүсэх зардлыг мөнгөн дүнгээр тооцоолон гаргана. Ийнхүү үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолно. Үүнд:

- хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
- нэг бүрийн зардлыг тооцох;
- тоон үзүүлэлтийг тооцох;
- нийт зардлын дүнг тооцож гаргах;
- хялбарчлах боломжийг шалгах;
- нэмэлт зардлыг тооцох.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд 170, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд 472 байна. Үүнээс төрийн өмчит хувьцаат компани 48, төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани 22, төрийн өмчийн оролцоотой компани 32, төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар 37 (23 нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөлөл хэрэгжүүлж байгаа, 14 нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, яамдын харьяа), төрийн өмчит улсын төсөвт үйлдвэрийн газар 28, хадгаламж, даатгалын корпораци нь сан хэлбэртэй, Монгол Улсын олон улсын гэрээгээр зохицуулагдаж байгаа Улаанбаатар төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэг 1 байна. Үйл ажиллагааны чиглэл нь уул уурхай, эрчим хүч, зам тээвэр, барилга, боловсрол, банк, санхүү, хэвлэл, амралтын газар, спортын ордон гэх мэт төрөл бүр байна.

Харин орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хувьд нийт 472 хуулийн этгээд байгаагаас өрхийн эмнэлэг 164, эм эргэлтийн сан 33 байна. Гэхдээ өрхийн эмнэлгүүд нь хуулийн этгээдийн статусын хувьд “БГБХН-Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл”, “ЗГБХН-зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл”-ийн хэлбэртэй буюу хуулийн этгээдийн өмчлөгч нь хувь хүн, иргэн байна. Харин санхүүгийн тайланд бүртгэлтэй хөрөнгө нь орон нутгийн өмчид бүртгэлтэй байна. Мөн эрүүл мэндийн байгууллагын хувьд төрөөс санхүүжин үйл ажиллагаа явуулж байна. Түүнчлэн эм эргэлтийн сангийн тухайд 29 нь орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, зарим нь хувьцаат компани хэлбэртэй, зарим нь хуулийн этгээдийн гэрчилгээгүй байна.

Нийт 472 орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой аж ахуйн нэгжээс нийт 275 хуулийн этгээд нь эмнэлэг, эм эргэлтийн сангаас бусад чиглэлийн аж ахуйн нэгж байгаа бөгөөд эдгээрийн 31 нь орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар, 200 нь орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, 13 нь хувьцаат компани, 31 нь хязгаарлагдмал хариуцлагатай компани байна.

Хуулийн төслийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт "Энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө үйл ажиллагаа явуулж байсан хувийн өмчит хуулийн этгээд гүйцэтгүүлэх боломжгүй аж ахуйн шинжтэй үйл ажиллагаа явуулдаг төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг энэ хуулийг дагаж мөрдсөнөөс хойш 1 жилийн хугацаанд компани хэлбэрт шилжүүлнэ." гэж заасан байх тул хуулийн төсөл батлагдснаар хувийн өмчит хуулийн этгээд гүйцэтгүүлэх боломжгүй аж ахуйн шинжтэй үйл ажиллагаа явуулдаг төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг компани болгох, хувийн өмчит хуулийн этгээд гүйцэтгүүлэх боломжтой аж ахуйн шинжтэй үйл ажиллагаа явуулдаг төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг хувийн өмчид шилжүүлэх зэрэг ажиллагаа явагдахаар байна гэж үзсэн. Иймд хичнээн төрийн болон орон нутгийн өмчит компани тус хуулийг дагаж мөрдөхийг тооцоолох боломжгүй тул одоо байгаа төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн тоогоор нэг хуулийн этгээдэд үүсэх зардлыг гаргахыг зорьлоо.

2.1.Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох:

Хуулийн төслөөр шинээр үүсч байгаа болон одоогийн хүчин төгөлдөр дагаж мөрдөж байгаа хуульд байгаа боловч уг үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай баримт бичгийн агуулгыг нэмэгдүүлсэн үүргийн хэмжээнд зардлын тооцоог хийх болно.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн³ Дөрөвдүгээр бүлгээр Төрийн өмчит хуулийн этгээд, түүний эд хөрөнгийн эрхийг одоогоор зохицуулж байна. Иймд уг хуульд заасан хуулийн этгээдэд хүлээлгэсэн үүрэгтэй давхцаагүй, эсхүл өргөжүүлсэн үүргийг сонгох болно. Хуулийн төсөлд хуулийн этгээдэд зардал үүсгэх дараах шинэ болон өргөжүүлсэн үүрэг⁴ байна. **Үүнд:**

- Төлөөлөн удирдах зөвлөл хувьцааны удирдлагыг хэрэгжүүлэгчид мэдээлэл хүргүүлэх;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар томилогдсон этгээд хувьцааны удирдлагыг хэрэгжүүлэгчид мэдээлэл хүргүүлэх зэрэг үүргийг гүйцэтгэхэд хуулийн этгээдэд үүсэх зардлыг тооцоолох болно.

Дээрх үүргүүдийг хуулийн төсөлд дараах байдлаар тодорхойлсон байна.

Хүснэгт 1

д/д	Хуулийн төсөл дэх холбогдох зохицуулалт	Үүрэг	Тайлбар
	/Хуулийн төслийн 20 дугаар зүйл/ 20 дугаар зүйл.Төлөөлөн	<u>Их хэмжээний, эсхүл эрх зүйн өндөр ач холбогдолтой хэлцлийг хийх тухай аливаа төлөвлөгөө; гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээний</u>	

³Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 1996 оны 11 дугаарт нийтлэгдсэн.


⁴Төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагааг одоогоор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хуулиар зохицуулж байх тул тус хуулийн төсөл дэх зарим үүргүүд нь өргөжүүлсэн, эсхүл өргөжүүлээгүй одоогоор төрийн болон орон нутгийн өмчит компани хэрэгжүүлэхээр эдгээр хуульд заасан үүргүүд болно.

<p>1.</p>	<p>удирдах зөвлөлийн гишүүний үүрэг</p> <p>20.1.Энэ хуулийн 19.5-д заасны дагуу компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон этгээд түүнийг томилсон, эсхүл томилуулахаар санал болгосон төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээдэд дараах мэдээллийг өгөх үүрэгтэй.</p> <p>20.1.1.компанийн аж ахуйн өдөр тутмын энгийн үйл ажиллагаанд үл хамаарах, <u>их хэмжээний, эсхүл эрх зүйн өндөр ач холбогдолтой хэлцлийг хийх тухай аливаа төлөвлөгөө;</u></p> <p>20.1.2.гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээний дагуу бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулсан талаарх мэдээлэл;</p> <p>20.1.3.төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээдээс тогтоосон хугацаанд, түүнээс баталсан загварын дагуу бэлтгэсэн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний ажлын нөхцөл байдлын талаарх мэдээлэл;</p> <p>20.1.4.Шилэн дансны тухай хуульд заасан төрийн болон орон нутгийн өмчит компанийн үүргийн гүйцэтгэл;</p> <p>20.1.5.компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллаж болохгүй нөхцөл байдал бий болсон талаарх аливаа мэдээлэл.</p>	<p>дагуу бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулсан талаарх мэдээлэл төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээдээс тогтоосон хугацаанд, түүнээс баталсан загварын дагуу бэлтгэсэн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний ажлын нөхцөл байдлын талаарх мэдээлэл; Шилэн дансны тухай хуульд заасан төрийн болон орон нутгийн өмчит компанийн үүргийн гүйцэтгэл; компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллаж болохгүй нөхцөл байдал бий болсон талаарх аливаа мэдээллийг хувьцааг удирдах этгээдэд тухай бүр өгөх</p>	
<p>2.</p>	<p>20.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар томилогдсон этгээд түүнийг томилсон, эсхүл томилуулахаар санал болгосон төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээдэд дараах мэдээллийг өгөх үүрэгтэй:</p>	<p>Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь хувьцааны удирдлагыг хэрэгжүүлэгчид төлөөлөн удирдах зөвлөлийн хурал хуралдахаас ажлын гурваас доошгүй өдрийн өмнө хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, хурал болсноос хойш 1 сараас доошгүй хугацааны дотор хурлаар хэлэлцсэн асуудалтай</p>	

	<p>20.2.1.төлөөлөн удирдах зөвлөлийн хурал хуралдахаас ажлын гурваас доошгүй өдрийн өмнө хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, хурал болсноос хойш 1 сараас доошгүй хугацааны дотор хурлаар хэлэлцсэн асуудалтай холбоотой тараасан материал, хурлын тэмдэглэлийн хуулбар;</p> <p>20.2.2.төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдахгүйгээр шийдвэр гаргасан бол шийдвэрийн төслийг гишүүдэд тараасан тухайн үеийн байдлаар болон санал өгсөн тухай мэдээлэл, санал хураалтын дүнг санал хураалт болсноос хойш ажлын 5 өдрийн дотор.</p>	<p>холбоотой тараасан материал, хурлын тэмдэглэлийн хуулбар; төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдахгүйгээр шийдвэр гаргасан бол шийдвэрийн төслийг гишүүдэд тараасан тухайн үеийн байдлаар болон санал өгсөн тухай мэдээлэл, санал хураалтын дүнг санал хураалт болсноос хойш ажлын 5 өдрийн дотор хүргүүлэх</p>	
--	--	---	--

2.2.Нэг бүрийн зардлыг тооцох

Энэ шатанд өмнөх шатанд тодорхойлсон хуулийн этгээдийн хүлээж буй үүрэг, түүнийг гүйцэтгэхэд нэг хуулийн этгээдээс зарцуулах мөнгөн зардлыг тооцоолон гаргана. Ингэхдээ дараах дарааллыг баримтална. Үүнд:



Стандарт үйл ажиллагаа болон зарцуулах хугацааг тодорхойлохдоо аргачлалын гарын авлагад бичигдсэн стандарт үйл ажиллагааны жагсаалтын дундаж хугацааг жишиг болгон авсан болно.⁵

Хүснэгт 2

№	Гүйцэтгэх үүрэг	Үүргийн агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа
1.	/Хуулийн төслийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг/	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн <u>их хэмжээний, эсхүл эрх зүйн өндөр ач холбогдолтой хэлцлийг хийх тухай аливаа төлөвлөгөө;</u> гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээний дагуу бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг	Үүрэгтэй танилцах	3 минут
			Мэдээлэл цуглуулах	3 минут
			Маягт бөглөх, гарчиглах, тэмдэглэх	3 минут
			Тооцоо хийх	3 минут
			Мэдээлэл, өгөгдөхүүнийг	5 минут

⁵Хуульд заасан үүргийг хэрэгжүүлэхэд тухайн хуулийн этгээдийн явуулах үйл ажиллагаа, түүнд зарцуулах цаг хугацааг дунджаар гаргасан олон улсын стандарт.

		зохион байгуулсан талаарх мэдээлэл төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээдээс тогтоосон хугацаанд, түүнээс баталсан загварын дагуу бэлтгэсэн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний ажлын нөхцөл байдлын талаарх мэдээлэл; Шилэн дансны тухай хуульд заасан төрийн болон орон нутгийн өмчит компанийн үүргийн гүйцэтгэл; компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллаж болохгүй нөхцөл байдал бий болсон талаарх аливаа мэдээллийг хувьцааг удирдах этгээдэд тухай бүр өгөх	нягтлах	
			Алдааг засах	2 минут
			Тоо баримтыг боловсруулах	3 минут
			Мэдээлэл шилжүүлэх	1 минут
			Олшруулах, архивлах, тараах	2 минут
Нийт хугацаа				25 минут
2.	/Хуулийн төслийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг /	Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь хувьцааны удирдлагыг хэрэгжүүлэгчид төлөөлөн удирдах зөвлөлийн хурал хуралдахаас ажлын гурваас доошгүй өдрийн өмнө хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, хурал болсноос хойш 1 сараас доошгүй хугацааны дотор хурлаар хэлэлцсэн асуудалтай холбоотой тараасан материал, хурлын тэмдэглэлийн хуулбар; төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдахгүйгээр шийдвэр гаргасан бол шийдвэрийн төслийг гишүүдэд тараасан тухайн үеийн байдлаар болон санал өгсөн тухай мэдээлэл, санал хураалтын дүнг санал хураалт болсноос хойш ажлын 5 өдрийн дотор хүргүүлэх	Үүрэгтэй танилцах	3 минут
			Мэдээлэл цуглуулах	3 минут
			Маягт бөглөх, гарчиглах, тэмдэглэх	3 минут
			Мэдээлэл, өгөгдөхүүнийг нягтлах	5 минут
			Мэдээлэл шилжүүлэх	1 минут
			Олшруулах, архивлах, тараах	2 минут
Нийт хугацаа				17 минут

Ажлын хэслийг тооцож гаргахдаа ажилтанд олгох сарын үндсэн цалинг ажиллах хугацаанд хувааж ажлын хөлсийг өдөр, цаг, минутаар гаргана.

Одоогийн байдлаар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд 170 байна.⁶ Үүнээс төрийн өмчит хувьцаат компани 48, төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани 22, төрийн өмчийн оролцоотой компани 32, төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар 37 (23 нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөлөл хэрэгжүүлж байгаа, 14 нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, яамдын харьяа), төрийн өмчит улсын төсөвт үйлдвэрийн газар 28, хадгаламж, даатгалын корпорацн нь сан хэлбэртэй, Монгол Улсын олон улсын гэрээгээр зохицуулж байгаа Улаанбаатар төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэг 1 байна. Харин аймаг, нийслэлийн орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй нийт 275 хуулийн этгээд байгаа бөгөөд эдгээрийн 31 нь орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар, 200 нь орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, 13 нь хувьцаат компани, 31 нь хязгаарлагдмал хариуцлагатай компани байна.

а.Төрийн өмчит компанийн нэг ажилтанд ногдох дундаж цалин

Төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудын нэг ажилтанд оногдох дундаж цалин тухайн байгууллагаас шалтгаалж харилцан адилгүй байгаа бөгөөд хамгийн бага нь 517.0 мянган төгрөг, хамгийн их нь 4,352.0 сая байна.⁷

Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаагаар нэг ажилтанд ногдох сарын дундаж цалин 2020 оны 4 дүгээр улирлын байдлаар **1328.1** мянган төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 203.8 (15.3 %) мянган төгрөгөөр нэмэгдсэн⁸ бол төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн нэг ажилтны сарын цалингийн жигнэсэн дундаж **1,580.0** мянган төгрөг, улсын төсөвт үйлдвэрийн газрын ажиллагсдын сарын дундаж цалин **1.063.0** мянган төгрөг байна.⁹ Төрийн өмчит аж ахуйн нэгжийн нэг сарын дундаж цалин улсын дундаж цалингаас 18 хувиар илүү, харин улсын төсөвт үйлдвэрийн газрын ажилтны сарын дундаж цалин улсын дундаж цалингаас 20 хувиар бага байна.

Иймд бодит байдал дээр төрийн өмчит аж ахуйн нэгжийн ажилтны сарын дундаж цалин нь улсын дундаж цалингаас дээгүүр, харин улсын төсөвт үйлдвэрийн газрын ажилтны сарын дундаж цалин нь улсын дундаж цалингаас доогуур байгаа тул төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн болон улсын төсөвт үйлдвэрийн газрын ажиллагсдын жигнэсэн дундаж цалингийн дундаж үзүүлэлтийг тооцоолон зардлын тооцоонд үндэслэл болгов. Өөрөөр хэлбэл, төрийн өмчит аж ахуйн нэгжийн нэг ажилтны сарын цалингийн жигнэсэн дундаж **1,580.0** мянган төгрөг + улсын төсөвт үйлдвэрийн газрын ажиллагсдын сарын дундаж цалин **1,063.0** мянган төгрөг : 2 = **1,321.5** мянган төгрөг төрийн болон төрийн өмчит компанийн нэг ажилтны сарын дундаж цалин байхаар тооцов. Энэ нь улсын дундаж цалин болох **1,328.1** мянган төгрөгтэй ойролцоо байна.

б.Орон нутгийн өмчит компанийн нэг ажилтанд ногдох дундаж цалин

Харин орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дунджаар 17,024 ажилтан ажиллаж байгаа бөгөөд жилийн дундаж цалингийн сан 173,052,590.05 төгрөг, нэг

⁶Төрийн болон орон нутгийн өмчит компанийн талаарх судалгаа.

⁷Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн судалгаа, Дэд ажлын хэсгийн тайлан 2020 он.

⁸Үндэсний статистикийн хорооны www.nso.mn веб хуудас.

⁹Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн судалгаа, Дэд ажлын хэсгийн тайлан 2020 он.

ажилтны сарын дундаж цалин **847.0** мянган төгрөг байна.¹⁰ Энэ нь улсын дундаж сарын цалинтай харьцуулахад 36 хувиар бага байна.

Ажиллах хугацааг тооцоолохдоо Хөдөлмөрийн тухай хуульд заасан хөдөлмөрийн цагийг үндэслэв.

Төрийн өмчит компанийн хувьд:

Ажлын хөлс = Үндсэн цалинг : ажиллах хугацаа
1.321.500 : 22 өдөр : 8 цаг : 60 минут = 125.1 төгрөг /нэг минутын хөдөлмөрийн хөлс/

Орон нутгийн өмчит компанийн хувьд:

Ажлын хөлс = Үндсэн цалинг : ажиллах хугацаа
847.000 : 22 өдөр : 8 цаг : 60 минут = 80.2 төгрөг /нэг минутын хөдөлмөрийн хөлс/

Дээрх үүргийг хэрэгжүүлэхэд нэг хуулийн этгээдэд үүсгэж байгаа зардлыг үйл ажиллагаа тус бүрд зарцуулж буй хугацааг ажлын хөлсөөр үржүүлэх замаар тооцоолох юм.

Хүснэгт 3

д/д	Гүйцэтгэх үүрэг	Зарцуулах хугацаа	Ажлын хөлс /минутаар/	Нэг бүрийн зардал
1.	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн их хэмжээний, эсхүл эрх зүйн өндөр ач холбогдолтой хэлцлийг хийх тухай аливаа төлөвлөгөө; гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээний дагуу бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулсан талаарх мэдээлэл төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээдээс тогтоосон хугацаанд, түүнээс баталсан загварын дагуу бэлтгэсэн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний ажлын нөхцөл байдлын талаарх мэдээлэл; Шилэн дансны тухай хуульд заасан төрийн болон орон нутгийн өмчит компанийн үүргийн гүйцэтгэл; компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллаж болохгүй нөхцөл байдал бий болсон талаарх аливаа мэдээллийг хувьцааг удирдах этгээдэд тухай бүр өгөх	25 минут	125.1/80.2 төгрөг	3037.5/2005 төгрөг

¹⁰Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2020 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/60-в тушаалаар байгуулагдсан дэд ажлын хэсгийн боловсруулсан "Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн судалгаа" 2020 он, 21 дүгээр тал.

2.	Төлөөлөн удирдах зөвлөлий дарга нь хувьцааны удирдлагыг хэрэгжүүлэгчид төлөөлөн удирдах зөвлөлийн хурал хуралдахаас ажлын гурваас доошгүй өдрийн өмнө хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, хурал болсноос хойш 1 сараас доошгүй хугацааны дотор хурлаар хэлэлцсэн асуудалтай холбоотой тараасан материал, хурлын тэмдэглэлийн хуулбар; төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдахгүйгээр шийдвэр гаргасан бол шийдвэрийн төслийг гишүүдэд тараасан тухайн үеийн байдлаар болон санал өгсөн тухай мэдээлэл, санал хураалтын дүнг санал хураалт болсноос хойш ажлын 5 өдрийн дотор хүргүүлэх	17 минут	125.1/80.2 төгрөг	2126.7/1363.4 төгрөг
----	--	----------	-------------------	----------------------

2.3.Тоон үзүүлэлтийг тогтоох:

Энэ үе шатанд өмнөх үе шатуудад тогтоосон Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл батлагдан гарснаар шинээр болж буй дээрх үүргүүдийг хичнээн хуулийн этгээд, жилд хэдэн удаа гүйцэтгэх вэ гэдгийг хуанлийн нэг жилээр тооцоолон гаргах юм.

Энэ үзүүлэлтийг гаргахын тулд тохиолдлын тоо болон давтамжийг холбогдох статистик мэдээ ашиглан тодорхойлж гаргах бөгөөд тэдгээрийн үржвэрээр “тоон үзүүлэлт” нь илэрхийлэгдэх юм.

ТОХИОЛДЛЫН ТОО x ДАВТАМЖ = ТООН ҮЗҮҮЛЭЛТ

Дээрх томъёог ашиглан хуулийн төсөл батлагдснаар шинээр нэмэгдэж байгаа гэж тодорхойлогдсон үүрэг тус бүрд тоон үзүүлэлтийг тогтоодог.

Харин хуулийн төслөөс үзэхэд дээрх үүргийг тухай бүр гүйцэтгэхээр байх тул давтамжийг тогтоох боломжгүй байна. Иймд энэ хэсэгт зөвхөн тохиолдлын тоог холбогдох статистик мэдээлэлд үндэслэн гаргана. Өөрөөр хэлбэл, хэдэн хуулийн этгээд хуулийн төсөлд заасан үүргийг гүйцэтгэхээр байгааг тооцоолов.

Төрийн өмчит аж ахуйн нэгж 170, орон нутгийн өмчит компани, үйлдвэрийн газар 275 байгааг зардлын тооцооны 9 дүгээр хуудсанд дурдсан болно. Иймд энэхүү статистик мэдээлэлд үндэслэн төрийн өмчит компани 170, орон нутгийн өмчит компани 275 байхаар тохиолдлын тоог тодорхойлов.

2.4.Нийт захиргааны зардлын дүнг тооцож гаргах:

Энэ үе шатанд өмнөх үе шатанд гаргасан үүрэг тус бүрд ногдох нэг бүрийн зардлыг тоон үзүүлэлтээр үржүүлснээр гаргах юм.

НЭГ БҮРИЙН ЗАХИРГААНЫ ЗАРДАЛ x ТООН ҮЗҮҮЛЭЛТ = НИЙТ ЗАРДАЛ

Хүснэгт 4

№	Гүйцэтгэх үүрэг	Нэг бүрийн зардал	х	Тохиолдлын тоо	=	Нийт зардал ¹¹
1.	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн <u>их хэмжээний, эсхүл эрх зүйн өндөр ач холбогдолтой хэлцлийг хийх тухай аливаа төлөвлөгөө</u> ; гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээний дагуу бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулсан талаарх мэдээлэл төрийн болон орон нутгийн өмчийн хувьцааг удирдах этгээдээс тогтоосон хугацаанд, түүнээс баталсан загварын дагуу бэлтгэсэн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний ажлын нөхцөл байдлын талаарх мэдээлэл; Шилэн дансны тухай хуульд заасан төрийн болон орон нутгийн өмчит компанийн үүргийн гүйцэтгэл; компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллаж болохгүй нөхцөл байдал бий болсон талаарх аливаа мэдээллийг хувьцааг удирдах этгээдэд тухай бүр өгөх	3037.5/2005 төгрөг	х	170/275	=	Төрийн өмчит компанийн хувьд 516.375 төгрөг Орон нутгийн өмчит компанийн хувьд 551.375

¹¹ “Нийт зардал” гэдэг нь уг хуулийн төсөл батлагдан гарснаар хуулийн төсөлд тусгагдсан үүргийг биелүүлэх нийт хуулийн этгээдэд дээрх үүргийг гүйцэтгэхэд нэг удаад үүсэх захиргааны зардал болно.

2.	Төлөөлөн удирдах зөвлөлий дарга нь хувьцааны удирдлагыг хэрэгжүүлэгчид төлөөлөн удирдах зөвлөлийн хурал хуралдахаас ажлын гурваас доошгүй өдрийн өмнө хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, хурал болсноос хойш 1 сараас доошгүй хугацааны дотор хурлаар хэлэлцсэн асуудалтай холбоотой тараасан материал, хурлын тэмдэглэлийн хуулбар; төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдахгүйгээр шийдвэр гаргасан бол шийдвэрийн төслийг гишүүдэд тараасан тухайн үеийн байдлаар болон санал өгсөн тухай мэдээлэл, санал хураалтын дүнг санал хураалт болсноос хойш ажлын 5 өдрийн дотор хүргүүлэх	2126.7/1363.4 төгрөг	x	170/275	=	<p>Төрийн өмчит компанийн хувьд</p> <p>361.539 төгрөг</p> <p>Орон нутгийн өмчит компанийн хувьд</p> <p>374.935 төгрөг</p>
----	--	----------------------	---	---------	---	---

2.5.Хувилбарыг нягталж, хялбарчлах боломжийн талаар

Хуулийн төслөөр хуулийн этгээдэд хүлээлгэсэн мэдээлэл хүргүүлэх үүргийг цахимаар шийдвэрлэвэл хуулийн этгээдэд үүсэх зардлыг багасгах, хялбарчлах боломжтой гэж үзэж байна.

Төрийн байгууллагууд хоорондоо мэдээлэл солилцох замаар олж мэдэх боломжтой баримт бичгийг хуулийн этгээдээс шаардахгүй байх нь нотариатаар батлуулах, хуулбарлах, хүргүүлэх, олшруулах зэрэг нэмэлт зардал, хүнд суртал, чирэгдлийг бууруулахад тодорхой нөлөөтэй гэж үзлээ.

2.6.Нэмэлт зардлыг тооцох:

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд хуулийн этгээдээс хуульд заасан үүргийг биелүүлэхийн тулд зайлшгүй төлөхөөр хуулиар тогтоосон төлбөр хураамж, тоног төхөөрөмж, материал зэргийг нэмэлт зардал гэсэн ойлголтонд хамруулах юм.

Хуулийн төсөлд зааснаас үзвэл, хуулийн этгээдэд нэмэлт зардал үүсэхээр зохицуулалт байхгүй байх бөгөөд төрийн болон орон нутгийн өмчит компаниуд одоо байгаа материал, тоног төхөөрөмжийн хүрээнд хуулийн төсөлд шинээр тусгасан үүргийг хэрэгжүүлэх боломжтой.

ГУРАВ.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Энэ бүлэгт Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийн төрийн захиргааны байгууллагад үүрэг оногдуулсан зарим зохицуулалтууд нь төрд ямар ачаалал, зардал үүсгэх магадлалтайг баримжаалан тооцоолох юм. Захиргааны байгууллагад үүсэх ачаалал, зардлын хэмжээг урьдчилан тооцох нь тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх төсөв, санхүүжилтийн

хэмжээ, хэрэгцээ, шаардлагыг тогтоох, мөн хуулийн зохицуулалтын хэрэгжих боломжийг тодорхойлоход нөлөөлөх хүчин зүйлийн нэг юм.

Хуулийн төслийн зохицуулалтаас үзвэл, хуулийн төслийн хэрэгжилтийг хангахад гол чиг үүргийг хүлээгч байгууллага нь Сангийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар байна. Харин орон нутгийн хувьд аймаг, нийслэлийн орон нутгийн өмчийн газар байна.

Одоо хүчин төгөлдөр дагаж мөрдөж байгаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт "Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөгчийг томилж, түүний үйл ажиллагаанд хяналт тавина." гэж, мөн хуулийн 21 дүгээр зүйлийн 15 дахь хэсэгт "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нийт төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны санхүүгийн үр дүн, тэдгээрээс төсвийн байгууллагын санхүү болон мөнгөн хөрөнгийн гүйлгээнд нөлөөлөх байдал, ажлын үр дүнд хяналт тавина." гэж тус тус заасан.

Иймд эдгээр байгууллага нь одоогийн хүний нөөцийн боломжоороо эдгээр хяналтын чиг үүргийг биелүүлэх боломжтой гэж үзэж байна.

Иймээс энэхүү судалгаагаар зөвхөн шинээр нэмэгдэж байгаа чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардал, ачааллыг тооцоолов. Хуулийн төслийн Гуравдугаар бүлэг дэх нэр дэвшүүлэх хороо болон үнэлгээний хороог шинээр үүсгэн байгуулахад төрөөс шаардагдах зардлыг урьдчилсан байдлаар тооцоолон гаргахыг зорилоо.

Эдгээр бүтцийг шинээр бий болгоход улсын төсөвт үүсэх зардлыг урьдчилсан байдлаар тооцоолох ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан аргачлалын дагуу дараах үе шаттайгаар гүйцэтгэлээ. Үүнд:

- 1.Нэр дэвшүүлэх хороо, үнэлгээний хороо байгуулах, үүнтэй холбогдон гарах зардал;
- 2.Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;
- 3.Гарах зардлыг урьдчилан тооцоолох;
- 4.Зардлыг нэгтгэн тооцоолох;
- 5.Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.

Нэр дэвшүүлэх хороо байгуулах, үүнтэй холбогдон гарах зардал

Хуулийн төслийн 16 дугаар зүйлд нэр дэвшүүлэх хороо, хорооны гишүүнийг сонгох, хорооны бүрэн эрх, түүний ажлын зохион байгуулалтын талаарх зохицуулалт орсон байна. Дээрх зохицуулалтуудаас харахад уг Хорооны үйл ажиллагаатай холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам зэрэг төрийн байгууллагууд хуулиар тогтоосон үүрэг хүлээж байна.

Иймд хуулийн төсөлд уг хуулийн хэрэгжилтийг хангахад гол үүрэг гүйцэтгэх үүрэг хүлээсэн Хороог үүсгэн байгуулах, үйл ажиллагаа явуулах тухай зохицуулалттай холбогдон үүсэх магадлалтай зардлыг урьдчилан тооцох болно.

Уг хуулийн төсөлд тусгаснаар нэр дэвшүүлэх хороо нь дарга, төр, олон нийтийн төлөөллөөс бүрдсэн 6 гишүүнтэй /16.4, 16.7./ байх ба төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг санал болгох үндсэн үйл ажиллагааг эрхлэн явуулах үүргийг хэрэгжүүлэн /16.1./ төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүнд нэр дэвшигчийг сонгох, албан тушаалаас чөлөөлөх, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо, бүрэн эрхийн хугацааг тогтоох, тэдгээрийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох /16.2./ бөгөөд даргыг гишүүд дундаасаа сонгох /16.8./, хорооны хуралд оролцсоны төлөө зохих хөлс, урамшуулал авч болох /16.11./-оор байна.

Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох

Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийг тодорхойлоход юуны өмнө тодорхой тоо баримт шаардлагатай болно. Эдгээр тоо баримт нь өнгөрсөн хугацаанд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн төлөөлөн удирдах зөвлөлд гишүүн томилох хэрэгцээ шаардлага, бүртгэлд тулгуурласан байх нь зүйтэй.

Хүний нөөцийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох ажлын хүрээнд Хорооны хурал зохион байгуулах, төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшиж буй гишүүдийг сонгон шалгаруулах ажиллагаатай холбоотой үүсэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон болно.

Нэр дэвшүүлэх хороо

Хуулийн төслийн 16 дугаар зүйлд нэр дэвшүүлэх хорооны тухай зохицуулалт орсон байна. Үүнээс үзэхэд Засгийн газрын шийдвэрээр байгуулагдан үйл ажиллагаа явуулах энэхүү хорооны үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх бөгөөд 6 гишүүнтэй, дундаасаа даргаа сонгохоор байна. Гишүүд нь хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга нар, эдгээрээс бусдыг нь Санхүүгийн зохицуулах хороо, Авилгатай тэмцэх газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимаас төрийн бус байгууллагыг санал болгож, тэдгээр дөврөн төрийн бус байгууллага нь тус бүр нэг хүнийг нэр дэвшүүлэх хороонд санал болгохоор байна.

Хорооны бүтэц, зохион байгуулалтыг харахад дарга болон гишүүдийн 2 нь төрийн болон төрийн захиргааны төв байгууллагад хариуцсан албан тушаалын дагуу гишүүнээр сонгогдож байгаа бол үлдсэн 4 гишүүн иргэний нийгмийн байгууллагаас сонгогдохоор зохицуулсан.

Хорооны гишүүдийн цалин хөлс, шагнал, урамшлын талаар зохицуулалтыг авч үзвэл, хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.11 дэх хэсэгт "Нэр дэвшүүлэх хорооны гишүүн хорооны хуралд оролцсоны төлөө зохих хөлс, урамшуулал авч болох ба хуралд оролцсоны улмаас гарсан зардлаа нөхөн төлүүлэх эрхтэй." гэж

заажээ. Иймд хорооны гишүүд нь хуралд оролцсоны төлөө зохих хөлс, урамшуулал авч болохоор байна.

Хуулийн төслөөс үзэхэд, хороо сард доод тал нь хэдэн удаа хуралдахаар заагаагүй байна. Хуралдааны зардлыг тооцохдоо ээлжит бус хуралдааны зардлыг оруулалгүй зөвхөн нэг сард нэг удаа буюу 1 жилд 12 удаа хуралдуулахаар тооцсон болно.

Хүснэгт 5

Гүйцэтгэх үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах үйл ажиллагаа/минут	Тохиолдлын тоо	Нийт хугацаа
Хорооны хурлыг сард нэг удаа	Мэдээлэх үүрэгтэй танилцах	3	12	36
	Мэдээлэл цуглуулах	3	12	36
	Мэдээллийг хянах, шаардлагатай баримт бичгийн бүрдлийг хянах	10	12	120
	Дотоод хуралдаан	30	12	360
	Шийдвэрийг албажуулах	15	12	180
	Олшруулах, тараах	2	12	24
	Нийт		63	12

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдсан ажиллах цагийн горимтой харьцуулах авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

- 1 жил = ажлын 200¹² өдөр
- 1 өдөр = ажлын 8 цаг /Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу/
- 1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу /200 x 8/ 1600 ажлын цаг буюу /1,600 x 60/ 96000 минут ажиллана гэсэн үг.

Нийт зарцуулах хугацаагаар хүний нөөцийн хэрэгцээ тодорхойлогдох ба тэрхүү хугацааг нэг жилд ажиллах ажлын минутад хувааснаар шаардлагатай

¹²Хуанлийн 365 хоногоос хөдөлмөрийн хуулинд заасан нийтээр амрах байрын өдөр, ээлжийн амралт, хагас бүтэн сайн өдөр зэргийг хасаж бодитой ажиллах өдрийг тооцно.

хүний нөөцийн хэрэгцээ буюу ажлын байрны тоо гарна. Үүнийг дараахь байдлаар гаргана.

<i>Хүснэгт</i>			
Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ	Жилд шаардагдах ажлын цаг/мин	Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/
Хорооны хурлыг зохион байгуулах	756 мин	96,000 мин	0.007

Үүнээс үзэхэд нэр дэвшүүлэх хорооны хурлыг зохион байгуулахад жилд дунджаар 756 минут буюу 12,6 **ажлын цаг** шаардагдах ба энэ нь 0,007 **хүний нөөцийн хэрэгцээг** илэрхийлж байна.

Нийт хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох

Хуулийн төсөлд тусгасан зохицуулалтаар зөвхөн нэр дэвшүүлэх хорооны хурал зохион байгуулах хуулиар хүлээлгэсэн үүргийг хэрэгжүүлэхэд **0,007** хүний нөөцийн хэрэгцээ үүсэх магадлалтайг юм. Иймд энэхүү хороо нь Засгийн газрын шийдвэрээр байгуулагдаж байгаа тул Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын одоогийн бүтэц орон тоогоор нэр дэвшүүлэх хорооны хурлыг зохион байгуулах боломжтой гэж үзэж байна.

Бусад зардал

Бусад зардалд төрийн байгууллагаас тухайн ажил үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой дагалдан гарах зардлыг авч үзнэ. Тухайлбал байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хөндлөнгийн хяналт, шалгалт хийлгэх, тусгайлсан програм хангамж боловсруулах, үйл ажиллагаагаа эхлүүлэхэд нэн шаардлагатай бараа материал худалдан авах гэх зэрэг зардлыг дурдаж болох юм.

Хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт "Нэр дэвшүүлэх хороо төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах тухай олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлана." гэж төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулахдаа нэр дэвшүүлэх хорооноос олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зар тавихаар тусгасан.

Зар тавих зардлыг судалж үзвэл, сонинд нэг удаа зар нийтлүүлэхэд тухайн сонины хуудсанд зарын эзлэх талбайгаас хамааран 5000-108.000 төгрөгийн ханштай байх бөгөөд дундаж үнэ нь **30,000 төгрөг** байна.

Түүнчлэн нэр дэвшүүлэх хорооны гишүүн хуралд оролцсоны төлөө зохих урамшуулал, хөлс авч болохоор хуулийн төсөлд тусгасан бөгөөд зөвхөн хуралд оролцсоны төлөө хөлс, урамшуулал авч болох тул хэдэн удаа оролцож, ямар хэмжээний урамшуулал, хөлс авахыг тооцох боломжгүй байх тул баримжаалан улсын дундаж цалин болох 1,328.100 төгрөгийг ажлын 22 өдөр, 8 цагт хуваан нэг цагийн дундаж цалин 7546 төгрөг байхаар баримжааллаа.

Хурлын хувьд дунджаар 2 цаг хуралдахад нэг гишүүн 15,092 төгрөгийн урамшуулал нэг хуралд оролцсоны төлөө авах магадлалтай байна.

Иймд нийт 6 гишүүнийн хувьд нэг хуралд оролцоход **90,550 төгрөг** улсын төсвөөс гарахаар байна.

Зардлыг нэгтгэн тооцох

Энэ үе шатанд төрийн захиргааны байгууллагаас буюу төрд үүсэх нийт зардлыг тооцож гаргана. Ингэхдээ хүний нөөцийн зардал, материаллаг зардлын нийлбэрийг хүний нөөцийн хэрэгцээнд үржүүлэн тооцох ба үүн дээр бусад зардлыг нэмснээр нийт зардлын хэмжээ гарах юм. Энэ тохиолдолд Хорооны хурлыг зохион байгуулахад шинээр хүний нөөцийн хэрэгцээ байхгүй буюу Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас одоогийн хүний нөөцийн боломжоороо хурлыг зохион байгуулах боломжтой гэж үзсэн тул бусад зардал болох төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах зар, нэр дэвшүүлэх хорооны гишүүн хуралд оролцсоны зохих хөлс, урамшууллаар нийт зардал тодорхойлогдоно.

Нэр дэвшүүлэх хороо төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах зар байршуулахад **30,000 төгрөг**, тус хорооны 6 гишүүн хуралд оролцсоны зохих хөлс нэг удаад нийт **90,550 төгрөг**-ийн нийт зардал үүсэх магадлалтай байна.

Хуулийн төслийн 10 дугаар зүйлд тусгасан үнэлгээний хорооны хурлыг зохион байгуулахад нэр дэвшүүлэх хорооны хурал зохион байгуулахад гарсан дээрх зардлаар баримжаалж болно. Харин хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт зааснаар үнэлгээний хороо нь орон тооны бус байх бөгөөд үнэлгээний хорооны ажиллах дүрэм, бүтэц, орон тоог Засгийн газар батлахаар заасан нь үнэлгээний хорооны гишүүнд холбогдох зардлыг тодорхойлох боломжгүйд хүргэж байх тул холбогдох зардлыг энэхүү судалгаанд тооцоолоогүй болно.

Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах

Хуулийн төсөлд тусгасан нэр дэвшүүлэх хорооны хурлыг зохион байгуулах болон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн сонгон шалгаруулах асуудлын хүрээнд төрд үүсэх зардлыг тоймлон тодорхойлохыг зорьсон.

Хурлыг цахимаар зохион байгуулбал олшруулах, хэвлэх, тараах зардал гарахгүй бөгөөд нэр дэвшүүлэх хорооны гишүүд хуралдаа биечлэн очилгүйгээр цаг хугацаагаа хэмнэх, цаашлаад сайн дурын үндсэн дээр иргэний нийгмийн төлөөллөөс бүрдэж байгаа тул хөлс, урамшуулалгүйгээр цахим хуралд оролцож, холбогдох зардал буурах боломжтой гэж харж байна.

ДӨРӨВ.ДҮГНЭЛТ, САНАЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн¹³ 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ыг баримтлан зардлын тооцоог гаргалаа.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл боловсруулагдахаас өмнө буюу одоогоор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар төрийн байгууллага, түүнчлэн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хуульд заасан тодорхой үүргийг хүлээж байгаа болно.

Хуулийн төсөлд тусгагдсан зардлыг тооцохын тулд бодит статистик болон хугацааг шууд ашиглах боломжгүй тохиолдолд аргачлалын 2.5.2, 4.4.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн адил төстэй ажил, үйлчилгээ байгаа эсэхийг судалж, баримжаалан авах зэргээр хугацаа, тохиолдлын тоо зэргийг тогтоосон бөгөөд тухай бүрт тайлбарыг оруулсан болно.

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын дагуу иргэнд үүсэх зардал нь цаг хугацаагаар, хуулийн этгээдэд үүсэх зардал нь мөнгөн дүнгээр, төрийн байгууллагад үүсэх зардал нь хүний нөөцийн хэрэгцээгээр тооцогдог. Эдгээр тооцож гаргасан зардлууд дээр “бусад зардал”, “нэмэлт зардал” буюу мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх зардлыг мөн тооцсон болно.

Хуулийн төслийн зохицуулалтаар буюу хуулийн төсөл батлагдсанаар зардал үүсгэгч этгээд болох хуулийн этгээд, төрийн байгууллагад тодорхой үүрэг бий болгосон, түүнийг хэрэгжүүлэхэд мөнгөн зардал бий болохоор тусгагдсан байна.

Одоо дагаж мөрдөж байгаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан хуулийн этгээдэд хүлээлгэсэн үүргүүдтэй хуулийн төсөл дэх адил төстэй үүргүүдэд зардал тооцоогүй бөгөөд шинээр бий болж байгаа төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, дарга нь хувьцааг удирдах эрхтэй этгээдэд мэдээлэл хүргүүлэх үүрэгт зардлыг тооцоолов.

Харин дээрх заалтыг хэрэгжүүлэхэд хуулийн этгээдэд үүсэх мөнгөн зардал захиргааны зардал нэг төрийн өмчит компанийн хувьд 5164.2 төгрөг, нэг орон нутгийн өмчит компанийн хувьд 3368.4 төгрөг, мэдээлэл хүргүүлэх тухай бүр, нийт 170 орчим төрийн өмчит компанийн хувьд 877.914 төгрөг, нийт 275 орон нутгийн өмчит компанийн хувьд 926.310 төгрөг мэдээлэл хүргүүлэх тухай бүр гарахаар

¹³ “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн.

байна. Үүнийг олшруулах, хэвлэх, тараах зардлыг бууруулахын тулд цахимаар мэдээллийг хүргүүлж хялбаршуулах боломжтой гэж үзэв.

Хуулийн төсөл нь улсын төсөвт хүний нөөцийн зардал үүсгэхээргүй бөгөөд харин бусад зардал болох нэр дэвшүүлэх хорооны гишүүдэд хуралд оролцсоны төлөө урамшуулал олгоход баримжаалж үзвэл, нийт 6 гишүүнд 90,550 төгрөг нэг хуралд оролцоход зарцуулах, харин төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулах зарыг өдөр тутмын хэвлэлээр зарлахад дундажаар 30,000 төгрөг тухай бүр гарч болохоор байна. Энэ зардал мөн орон нутгийн өмчит компанийн хувьд ойролцоогоор үүсэх боломжтой.

Үүнийг хялбарчлах тухайд, нэр дэвшүүлэх хорооны хурлыг цахимаар зохион байгуулах, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалтыг цахимаар нээлттэй сонголт хийх зэргээр үр өгөөжтэй бөгөөд хуралд оролцох гишүүдийг зайнаас ажиллах боломжийг эрэлхийлбэл сайн дурын үндсэн дээр оролцож байгаа иргэний нийгмийн төлөөлөл болсон гишүүдэд хөлс, урамшуулал төлөхгүй байх боломжтой гэж үзсэн. Мөн албан тушаалын хувьд хуралд оролцож байгаа хууль зүйн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл хуралд оролцсоны төлөө урамшуулал авахгүйгээр шийдвэрлэж болох юм.

Хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардлын үр өгөөж нь зардлаасаа их байна. Учир нь хуулийн төсөл батлагдсанаар төрийн болон орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг нээлттэй, хараат бусаар сонгох, улмаар төлөөлөн удирдах зөвлөлд чадвартай, хараат бус гишүүд томилогдох нөхцөл бүрдэх, компани байгуулахдаа тооцоо судалгаанд үндэслэн хувийн хэвшил гүйцэтгэх боломжгүй салбарт байгуулдаг болох, төрийн болон орон нутгийн өмчит компани алдагдалтай бол хэрхэх, ашигтай, ил тод, хариуцлагатай ажиллах, хувийн хэвшлийн өрсөлдөх боломжийг булаахгүй байх, улсын төсөвт дарамт үүсгэхгүй байх зэрэг нийгэм, эдийн засагт эерэг үр өгөөжтэй байна.

-----oOo-----

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

I. Хууль тогтоомж, эрх зүйн акт

1. Хууль тогтоомжийн тухай хууль
2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
3. Хөдөлмөрийн тухай хууль
4. Засгийн газрын 2016 оны 59 дүгээр торгтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал"

II. Бусад ашигласан материал

1. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал
2. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийн эхний хувилбар
3. Хуулийн төслийн таницлуулга
4. ТӨБЗГ-ын даргын 2020 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн тушаалаар байгуулагдсан дэд ажлын хэсгийн боловсруулсан "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн судалгаа", "Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн судалгаа" 2020 он

III. Цахим эх сурвалж

1. <http://www.legalinfo.mn>
2. Үндэсний статистикийн хорооны www.nso.mn веб хуудас.